



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2013 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 164

Улаанбаатар хот

Г “Хүнгэлдуут” ХЗХ-ны хадгаламж, Г  
зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай  
зөвшөөрлийг сунгах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6.2, 10.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам”-ын 9.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Хүнгэлдуут” ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг 2013 оны 4 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар сунгасугай.
2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд сунгасан талаарх тэмдэглэгээг 2013 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн дотор хийлгэхийг “Хүнгэлдуут” ХЗХ /Ө.Цэндсүрэн/-нд үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН



000295